МЭДЭЭ · 2024 оны 5-р сарын 9

ПРОКУРОР 259 ГОМДОЛ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭВ



Прокурорын байгууллага 2024 оны 5 дугаар сарын 02-ноос 09-ний өдрийг хүртэл хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан 337 гомдол, хүсэлтийг шинээр хүлээн авч, нийт 969 гомдол, хүсэлтийг хяналаа. Хүлээн авсан гомдол, хүсэлтийн дийлэнх нь эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой байна. Харин шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгуулах 3, ял эдлүүлэх ажиллагаатай холбогдох 6 гомдлыг хүлээн авчээ.

Дээрх хугацаанд 259 гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэж, одоо 710 гомдол, хүсэлтийг хянаж байна.

Мөн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав, Мишээл салбар дахь "Прокурорын байгууллагын нэг цонхны үйлчилгээ үзүүлэх төв"-үүд 15 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч харьяа прокурорын газарт нь шилжүүлж, прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө мэдээллийг 34 иргэнд өгч ажиллажээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1176